

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4 дүгээр хэвсрэлт

<b>2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/</b>	
<p>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</p>	
Тайлангах хугацаа	2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 30 өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	<p>"Тавантолгой" ХК                      Регистрийн дугаар: 2016656                      Улсын бүртгэлийн дугаар: 1110001006                      Үнэт цаасны код: TTL                      Утас: 7535-5555, 9500-1619</p>
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Уул уурхай, Нүүрс олборлолт
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	52,665,200 ширхэг
Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	<p>Бэлтгэсэн: Захиргаа, санхүүгийн газрын захирал: Ч.Төрмандах                      Хянасан: Гүйцэтгэх захирал: Ч.Гүнждагва</p>
1	Хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/
	<p>Санхүүгийн байдлын үзүүлэлт</p> <p>2024 оны эхний хагас жилд нийт хөрөнгийн дүн 706,468.4 сая төгрөг, үүнээс эргэлтийн хөрөнгө 96.1 хувь буюу 679,003.7 сая төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 3.9 хувь буюу 27,464.7 сая төгрөгийг эзэлж байна. Нийт эх үүсвэр 706,468.4 сая төгрөг, үүнээс өр төлбөр 210,611.0 сая төгрөг, хуримтлагдсан ашиг 489,886.7 сая төгрөг байна.</p> <p>2024 оны хагас жилийн санхүүгийн тайлан хавсаргав.</p>
	<p>Орлогын тайлан</p> <p>2024 оны эхний хагас жилд 518,468.5 сая төгрөгийн орлоготой, 243,310.3 сая төгрөгийн зардалтай, 256,932.3 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.</p>

	Өмчийн өөрчлөлтийн тайлан	2024 оны эхний хагас жилд 256,932.3 сая төгрөгийн татвар төлөхийн өмнөх ашигтай ажиллаж эздийн өмчийн дүн 495,857.4 сая төгрөг болсон байна.
	Мөнгөн гүйлгээний тайлан	2024 оны эхний хагас жилд бүх цэвэр мөнгөн гүйлгээ 299,938.5 сая төгрөг, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл 418,490.1 сая төгрөг байна.
2	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт	
3	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт	
3.1	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Нийт ашгийн хувь 53.07% Эздийн өмчийн өгөөж /ROE/ 0.43 Нийт хөрөнгийн өгөөж /ROA/ 0.30
3.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Эргэлтийн харьцаа: 3.2 Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа: 2.3
3.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	Компанийн үндсэн үйлдвэрлэлийн тоо хэмжээг Өмнөговь аймгийн ИТХурлаас өгсөн чиглэлийн дагуу нэмэгдүүлэн ажиллах төлөвлөгөөний дагуу ажилласан. "Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам" болон зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан борлуулалт хийж ажилласан. 2024 оны эхний хагас жилд 1.1 сая түн нүүрс борлуулсан. Энэ үзүүлэлт нь өнгөрсөн оны мөн үеийн үзүүлэлтээс 10.1 дахин өссөн үзүүлэлттэй байна. Түүхий эдийн үнийн өсөлт, ажиллах хүчний хомсдол, инфляцын өсөлтөөс шалтгаалж хөрс хуулалтын зардал өссөн, Нүүрсний үнийг гадаад зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан оновчтой зохион байгуулж ажилласан.

3.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	"Тавантолгой" ХК нь 2024 оны эхний хагас жилд Санхүүгийн байдлын тайлангаас гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй, НБББодлого нь компанийн НББББичгийн дагуу бүртгэсэн.
3.5	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	"Тавантолгой" ХК нь эргэлтийн хөрөнгөөр санхүүжиж ямар нэгэн зээл аваагүй ажилласан.
4	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй.		
5	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	
Тайлант хугацаанд санал болгон хувьцаа гаргаагүй.		
6	Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой мэдээлэл	
<p>➢ "Тавантолгой" ХК нь компанийн засаглалын бүтцийн хувьд дараах бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хувьцаа эзэмшигчдийн хурал,</li> <li>- Төлөөлөн удирдах зөвлөл, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга,</li> <li>- Гүйцэтгэх захирал,</li> <li>- Газрын захирал,</li> <li>- Хэлтсийн захирал,</li> <li>- Албаны дарга,</li> </ul> <p>➢ Тайлант хугацаанд компанийн удирдлагын хүрээнд дараах үйл ажиллагаа явагдсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• <u>Хувьцаа эзэмшигчдийн хурал</u>: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 14 цагаас компанийн төв байранд зохион байгуулсан. Хуралтай холбоотой мэдээллийг холбогдох журмын дагуу олон нийтэд мэдээлэх, холбогдох мэргэжлийн байгууллагад хүргүүлэн ажилласан.</li> <li>• <u>ТУЗ-ийн гишүүд</u>: Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 9 гишүүн (хараат бус 3 гишүүн, ердийн 6 гишүүн) сонгон ажилласан.</li> <li>• <u>ТУЗ-ийн дэргэдэх хороод</u>: Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд Аудитын хороон, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороог байгуулан ажиллаж байна.</li> <li>• <u>ТУЗ-ийн хурал</u>: Үйл ажиллагааны журамд заасны дагуу хурлын үйл ажиллагааг</li> </ul>		

	зохион байгуулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хооронд ..... удаагийн танхимын болон танхим, цахим хосолсон хурлаар ..... тогтоол гарган ажилласан.
Мэдээлэл гаргач этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: Ч.Гүнждагва Албан тушаал: "Тавантолгой" ХК-ийн гүйцэтгэх захирал Гарын үсэг: ..... (Тамга/тэмдэг) .....	
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: Ч.Төрмандах Албан тушаал: "Тавантолгой" ХК-ийн Захиргаа, санхүүгийн газрын захирал Гарын үсэг: .....	

COAL MINING

COKING COAL

LOOSE COKING

ENERGY COAL

TAVANTOLGOI

JOINT STOCK

COMPANY

SINCE 1966



# ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН 2024

TAVANTOLGOI JOINT STOCK COMPANY




## АГУУЛГА

- 1** **Салбарын мэдээлэл**  
Монгол улсын үйл уурхайн салбарын мэдээлэл
- 2** **Компанийн мэдээлэл**  
Компанийн мэдээлэл  
Бүтэц зохион байгуулалт  
Хүний нөөцийн мэдээлэл  
Үндсэн үйлдвэрлэл  
Санхүүгийн үзүүлэлт
- 3** **Биржийн арилжааны мэдээлэл**  
Үйл уурхайн бүтэцдэхүүний биржийн  
түрээх зуулийн хэрэгжилт  
Тээвэр, логистикийн мэдээлэл
- 4** **Хувьцааны мэдээлэл**  
Хувьцаа, ногдол ашгийн хуваарилалт
- 5** **ХАБЗАБО-ны мэдээлэл**  
Харгалмэрийн асуултгүй байдал эрүүл ахуйн  
Байгаль орчны нөхцөлөөр  
Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хуранд
- 6** **Тогтвортой хөгжил**  
Нийгмийн хариуцлага, хамтын ажиллагаа
- 7** **Онцлох үйл явдал**  
2024 оны онцлох үйл явдалууд



**УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ОРЛОГО**  
(тэрбум төг)



Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрийн 2024 оны эхний хагас жилд үндэслэн гүйцэтгэлээр 11.2 их наяд төгрөг болж, өмнө оны мөн үеэс 1.9 (21.1%) их наяд төгрөгөөр өсөвөгчлүүлэн болон хүрэн нүүрс олборлолт 1.9 (52.9%) их наяд төгрөгөөр, бусад ашигт малтмал олборлолт 45.6 (42.6%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь толион нөлөөтэй байна.

**МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙН  
САЛБАРЫН  
МЭДЭЭЛЭЛ**



**КОМПАНИЙН  
МЭДЭЭЛЭЛ**




Тусгай хэл аймагийн Төв, түүхэн түүнэж ирээдүйн "Их шэнхлэг" үүлэн ойролцоо нутаг ордогийн Өвчлөх аймагийн Цогцсүхий сум, Цэцэг үүлэн баруун хойд эгд таван жилийн тэртэй тэртэйгээр нэрээдгэн ордог.

1966 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 124 тоот тогтоолоор эгд гэрлэг үүлэн өмнө болгож, үйлдвэрийн эргээр ашиглаж болсон ба 1967 оны 5 дүгээр сарын 01-ээс эрэн нутгийн өмнөг бие даасан уурхай болж орлонсон.

"Тавантөглөг"ХК нь эдгээр ажилд андгдч болгож ажилтдаар баталг ажилуулан гэрлэг нь ажилуулан Махил үүлэн УУГАН уурхайнуудын нэг юм. Ийн гэрлэг зүүнээс зүүнд тус тус, эрүүн ажилтдаар 58 жилийн түүхтэй орлонсон үс үүлэн уурхай-эрэн хэлс, хдрлмэр ажилт бүхэгд нь ажилуулан баарил дүүрэн хамт олон юм.





**БҮТЭЦ  
ЗОХИОН  
БАЙГУУЛАЛТ**



**ХҮНИЙ НООЦИЙН МЭДЭЭЛЭЛ**

Компанийн үндсэн ажиллагс 2000. Гэрээт болон туслах гүйцэтгэлч 83 компани. Аж ахуй нэгжийн хэмт 4537 хүнийг агуулан байрлар ханган ажилладаг байна.

**ҮНДСЭН  
ҮЙЛДВЭРЛЭЛ**



**БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТ /Биет хэмжээгээр/**

	Хэмжээ нэгж	2022H1	2023H1	2024H1	Өөрчлөлт 2023/2024
Хөрс хуураалт	сая.м3	5.41	5.59	11.86	112.2%
Нүүрс олборлолт	сая.тн	1.27	0.69	2.33	137.7%
Уулын цул	сая.м3	6.32	6.08	13.98	129.9%
Нүүрс борлуулалт	сая.тн	1.03	0.10	1.11	1011.5%
Үүнхэс: Экспорт	сая.тн	0.98	0.06	0.99	1551.6%
Дотоод	сая.тн	0.05	0.04	0.12	201.3%
Хөрс хуураалтын коэффициент	м.куб/тонн	4.27	8.12	5.08	-37.4%

**ХӨРС ХУУЛАЛТ**



**УУЛЫН ЦУЛ**



**НҮҮРС ОЛБОРЛОЛТ**



**НҮҮРС БОРЛУУЛАЛТ**



**САНХҮҮ БАЙДЛЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН /Аудитлагдаагүй/**

	2023Н1	2023Н1	2024Н1	Өөрчлөлт 2023/2024
<b>ХӨРӨНГӨ</b>				
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	196.45	366.04	829.62	126.6%
Үндсэн хөрөнгө	35.08	38.31	27.41	48.1%
Бэлтгэсэн хөрөнгө	1.23	1.11	1.19	7.7%
Бусад хөрөнгө	0.43	1.05	0.43	-56.6%
Нийт хөрөнгө	233.19	386.70	858.66	122.0%
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭХДИЙН ӨМЧ</b>				
Өр төлбөр	117.46	121.14	553.10	254.6%
Богноо хугацаат өр төлбөр	117.46	121.14	553.10	254.6%
Үрт хугацаат өр төлбөр	-	-	-	-
Бусад өр төлбөр	-	-	-	-
Эхдийн өмч	95.74	265.56	305.56	13.1%
Өмч	0.09	0.09	0.09	-
Хөрөнгө даам үнэлгээний нэмэгдэл	0.47	0.47	5.88	11.3 дахин
Хуримтлагдсан эзэл	95.18	265.00	299.59	11.1%
Нийт өр төлбөр ба эхдийн өмч	213.19	386.70	858.66	122.0%

**САНХҮҮГИЙН  
ҮЗҮҮЛЭЛТҮҮД**



**НИЙТ ХӨРӨНГӨ**



**ТЭЭВЭР,  
ЛОГИСТИКИЙН  
МЭДЭЭЛЭЛ**



“ 2024 оны эхний хагас жилд 2023 онд Төрийн худалдан авах ажиллагааны газартай хамтран ачаа тээврийн Ерөнхий гэрээ байгуулан ажиллаж байсан 68 компанитай үргэлжлүүлэн хамтран ажилласан. Мөн эдгээр компанийн давхардсан тоогоор 2231 жолоочийг ажлын байраар хангасан. Нүүрс тээврийн “С” эвшөөрлийн бичгийг 2024 оны эхний хагас жилд нийт 844 ширхэгийг олгосон.

**ТЭЭВРИЙН ӨРӨНХИЙ ГЭРЭЭТ АЖ АХУЙ НЭГЖҮҮД**

- » Уртын тээврийн ерөнхий гэрээт компани 220км-42
- » Богнын тээврийн ерөнхий гэрээт компани 30км-10
- » Терминалийн тээврийн ерөнхий гэрээт компани 8км-



**2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД  
НҮҮРСНИЙ АЧАА**


- » Уртын тээврийн /Тавантолгой ХК - Цагаан хад/ чиглэлд ачаа тээврийн 48 гэрээ
- » Богнын тээврийн /Цагаан хад - Ганц мод/ чиглэлд ачаа тээврийн 18 гэрээ
- » Терминалын тээврийн /ЧТТ - Ганц мод/ чиглэлд ачаа тээврийн 23 гэрээ
- » Нийт 89 ачаа тээврийн гэрээ байгуулан



	2023/1-6	2024/1-6	Өөрчлөлт 2023/2024
<b>ХУВЬЦААНЫ ҮНД (төгрөг)</b>			
Хамтын үнэ	6,180	17,190	33.5%
Хамгийн их үнэ	16,190	28,940	78.8%
Хамгийн бага үнэ	8,148	17,190	70.9%
Дундаж үнэ	11,208	23,713	53.4%
<b>АРИВХААЛДСАН ТОО (америк)</b>			
Хамтын их /америк/	24,444	9,251	-62.2%
Хамгийн бага /америк/	39	5	-87.2%
Дундаж /америк/	1,592	1,424	-10.6%
Нийт	199,655	177,967	-10.6%
<b>АРИВХААЛДСАН ҮНЭЙН ДҮН (төгрөг)</b>			
Хамтын их /америк/	243,695,000	237,505,000	-1.7%
Хамгийн бага /америк/	318,130	313,500	-64.3%
Дундаж /америк/	38,772,502	34,431,855	-10.7%
Нийт	2,344,502,690	4,308,481,000	83.7%
<b>ЗАХ ЗЭЭЛЭЙН НӨЙТ ҮНЭ (төгрөг)</b>			
	590,376,892,000	1,426,173,616,000	141.5%

2024 оны 01 дугаар сарын 02-ны өдрөөс 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хуртал хувьцааны хэцэ 17,190 төгрөгөөс 27,080 төгрөг болж 57.5%-иар буюу 9,890 төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Дээрх хугацаанд 177,967 шархэг хувьцааны 4.3 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

### ХУВЬЦААНЫ ХАНШИЙН МЭДЭЭЛЭЛ



13 2024 оны хагас жилийн тайлан ТАВАНТОЛГОЙ ХК

### ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ



#### БАРИМТ БИЧИГ, ЖУРАМ

ТАВАНТОЛГОЙ ХК-н хөдөлмөрийн аюулгүй байдлын бичиг баримтын бүрдлийг ISO 45001:2018 стандартыг нэвтрүүлэх зорилт тавин ажиглаж байна.

#### ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ

Үзүүлэлт	Хувий тоо
Яаралтай тусламжийн нэгжээр үйлчлүүлэгчдийн тоо /дежидсан тоогоор/	806
Даралт болон гэржлийн өрчилгүүгчдийн ажилт /даралт хэмээлт дежидсан тоогоор/	443
Ажлын бүртгэсэн	13

#### АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАЛ АЛДАЛТҮҮЙ  
**1725 хоног,  
 1,947,790 хүн/цаг**  
 АЮУЛ ОСОЛГҮЙ АЖИЛЛАГАА

#### БЭРТЭЛ ГЭМТЛИЙН ДАВТАМЖ 0.00

#### АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ СУРГАЛТ 17632 хүн/цаг



**ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ**

Шимт хөрс хуулалт, хадгалалт MN5 5916 : 2008 стандартын дагуу шимт хөрсний овоолгын 1 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг үе шаттайгаар хэрэгжүүлж олон наст өвслөг ургамал тарин ажиллаж байна.



**БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ**

Хаягдал овоолгын 2.3 га талбайд олон настын үр цацаж, усалгааны систем суурилуулж биологийн нөхөн сэргээлт хийж технологийн арчилгаа усалгааг хувиарын дагуу тогтмол хийж байна.

**БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛЭЭР**



**НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Уурхайн технологийн замын орчны тоосжилт бууруулах зорилгоор тоос барьцуулдагч бодисыг туршиж цаашид орчны тоосжилтыг бууруулах арга хэмжээг төлөвлөж ажиллаж байна.



**БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛЭЭР**



**ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

**ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ:**

Богд Хан уулын Хүүшийн аман дахь 23,3 га талбайд 2 овгийн 4 төрлийн 50,000 ширхэг шилмүүст модны суулгац тарихаар төлөвлөн, төсвийг шийдвэрлэж, Богдхан уулын хамгаалалтын газрын захиргаа, Ойн газар, БОАЖЯ-тай гэрээ байгуулан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу бэлтгэлийг ханган ажиллаж байна.





**"НОГООН ГОВЬ БИД БҮТЭЭНЭ"** уриан дор нийт 7,5 сая модыг 2020-2030 онд тариалахаар төлөвлөн ажиглаж байна.

## ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилга "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд "НОГООН ГОВЬ БИД БҮТЭЭНЭ" уриан дор нийт 7,5 сая модыг 2020-2030 онд тариалахаар төлөвлөн ажиглаж байна. Уг ажлын хүрээнд мод үржүүлэг, ойжуулалтын ажлыг үр дүнтэй хэрэгжүүлж Өмнөговь аймгийн Даланзадгад, Цогтцэций, Булган, Номгон сумдад урт хугацааны төсөл хөтөлбөрийг эхлүүлээд байна.

Өмнөговь аймгийн Ногоон хэрэм төслийн ойжуулсан 50 га талбайд мод үржүүлгийн газар байгуулах ажлыг эхлүүлж Даланзадгад суманд бүс нутгийн онцлогт тохирсон 1,782,294 ширхэг тарьцыг үржүүлээ.



## ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

“ГЭМТ ХЭРЭГ ЗӨРЧЛИЙГ БУУРУУЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗОРИЛГООР КАМЕРЫН НЭГДСЭН СИСТЕМ СУУРЬЛУУЛАХ АЖЛЫГ ЭХЛҮҮЛЛЭЭ”

"Тавантолгой"ХК-ийн 2024 оны бизнес төлөвлөгөөнд тусгасны дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций суманд камерын иж бүрэн систем суурьлуулах ажлыг эхлүүлээ. Ингэснээр хүн амын хөдөлгөөн ихтэй бүс нутгийн хувьд гэмт хэргийн зөрчил буурах, иргэд аюулгүй орчинд ажиллаж амьдрах таатай нөхцөл бүрдэх юм.

“МАЛЧДАДАА ТУСАЛЪЯ” АЯНЫ ХҮРЭЭНД ХҮНС, ЭРҮҮЛ МЭНД, АХУЙН БАГЦ ГАРДУУЛЛАА

Компанийн ТУЗ-ийн шийдвэрээр нийгмийн хариуцлагын хүрээнд МАЛЧДАДАА ТУСАЛЪЯ аяныг өрнүүлж Өмнөговь аймгийн нийт малчдад НЭГ ТЭРБУМ төгрөгийн дэмжлэг үзүүлж Аймгийн Онцгой комисст гардуулан өгсөн. Мөн өвөлжилт, хаваржилт хүндэрсэн Цогтцэций, Мандал-Овоо, булган сумын нийт 1231 малчин өрхөд шатахууны талон, өдөр тутмын хэрэгцээний хүнс болон эрүүл мэндэд хэрэгцээтэй дархлаа дэмжих бүтээгдэхүүн бүхий багц гардуулав.







**ШИЛДЭГ ТАТВАР ТӨЛӨГЧ "ТАВАНТОЛГОЙ" ХК**

Орон нутгийн өмчит "Тавантолгой"ХК нь улс эх, орныхоо өмнө хүлээсэн үүргээ амжилттай биелүүлж орон нутаг, иргэдэд өгч буй ногдол ашиг, нийгмийн хариуцлагын хүрээнд хийж хэрэгжүүлж буй олон төсөл арга хэмжээг өнгөрөгч онуудад хийж гүйцэтгэж чадсан шилдэг хамт олон. Өнгөрөгч онд 3.5 сая тонн нүүрс олборлон борлуулж 1.1 их наядын борлуулалтын орлоготой ажиллаж улс болон орон нутгийн татварт нийт 298.3 тэрбум төгрөг төвлөрүүлэн Монголын татварын газрын 2023 оны хамгийн их татвар төлсөн шилдэг 10 аж ахуй нэгжээр шалгарч ШИЛДЭГ ТАТВАР ТӨЛӨГЧ боллоо.



**ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ**



**ХАМТЫН ГЭРЭЭНД ТАЛУУД ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА**

"Тавантолгой" ХК-ийн 2024-2027 онд мөрдөгдөх захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хороо хооронд байгуулсан хамтын гэрээний хэлэлцээр амжилттай болж талууд гарын үсэг зурж баталгаажууллаа. Тус гэрээгээр ажилчдын нийгмийн асуудал, хөдөлмөрлөх эрх, хөдөлмөрийн аюулгүй байдал, цалин хангамжийн асуудал зэрэг олон асуудлыг уурхайчдын эрх ашигт нийцсэн байдлаар тусгах мөрдөн ажиллах юм.



**ДОТООДОД БОРЛУУЛАХ НҮҮРСНИЙ НЭЭЛТЭЙ ДУУДЛАГА ХУДАЛДАА БОЛЛОО**

"Тавантолгой"ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн шийдвэр, "Дотоодод борлуулах нүүрсний нээлттэй дуудлага худалдааны журам"-ын дагуу 2024 оны 05 дугаар 22-ний өдөр анхны дуудлага худалдааг амжилттай зохион байгуулж 10 багц 50,000 тонн 1/2 барьцалдаж нүүрсийг тонн тутмыг нь 126,000 мянган төгрөгөөр борлууллаа.



**КОМПАНИЙН АРХИВЫН БАРИМТЫГ ТӨРИЙН АРХИВТ ХҮЛЭЭЛГЭН ӨГЛӨӨ**

"Тавантолгой" ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/59 дүгээр тушаалаар томилогдсон ажлын хэсэг 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс 06 дугаар сарын 20-ны өдрүүдэд компанийн архивын баримтыг цэгцлэх ажлыг зохион байгуулж 1979-2022 оны байнга болон 70 жил хадгалах 678 баримтыг хүлээлгэн өглөө.



#### АВТОМАТ УДИРДЛАГАТАЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АГУУГАРЦААР НҮҮРС ЭКСПОРТЫН ТЭЭВРИЙГ ЭХЛҮҮЛЛЭЭ.

Нүүрсний экспортыг эрчимжүүлэх ажлын хүрээнд 2024 оны 5 сараас эхлэн "Смарт эко транс" ХХК-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулж Гашуунсухайт боомт дахь автомат удирдлагатай тээврийн хэрэгслийн терминалаар экспортын тээврийг эхлүүлээд байна. Энэхүү гарцаар өдөрт 100 тээврийн хэрэгсэлээр 14,000 тонн



#### БНХАУ-ЫН БЭЭЖИН ХОТОД "МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН ӨДӨРЛӨГ" БОЛЛОО

"Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний биржийн өдөрлөг"-ийг БНХАУ-д суугаа МУ-ын Элчин сайдын яам, Санхүүгийн зохицуулах хороо, Уул уурхайн ассоциаци, Монголын хөрөнгийн бирж хамтран зохион "Тавантолгой" ХК-ийн төлөөлөл оролцож үйл ажиллагаагаа танилцууллаа. Өдөрлөгт БНХАУ-ын 70 гаруй худалдан авагч компани, Монгол улсаас уул уурхайн бүтээгдэхүүний брокерийн 7 компани оролцов.

